



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/325

Улаанбаатар хот

Чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, Бага, дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж буй суралцагчийг үнэлэхэд баримтлах чиглэл”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Батлагдсан чиглэлийн хэрэгжилтийг арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Бага, дунд боловсролын газар /Т.Ням-Очир/, аймаг, нийслэлийн Боловсролын газарт, сургалтын байгууллагын удирдлага, багш нарт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэхийг Боловсролын үнэлгээний төв /Л.Ганбат/-д тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт үүрэг болгосугай.

САЙД



Д.ЭНХ-АМГАЛАН

142111229

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021
оны 129 дүгээр сарын 16-ний өдрийн
А/325 дугаар тушаалын хэвсрэлт

ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГӨӨР ХИЧЭЭЛЛЭЖ БУЙ СУРАЛЦАГЧИЙГ ҮНЭЛЭХЭД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Нэг. Ерөнхий зүйл

1.1.Ерөнхий боловсролын сургуульд ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж буй суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагын өөрчлөлт ахиц, амжилтыг үнэлж, дүгнэхэд энэхүү чиглэлийг баримтална.

1.2.Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж буй суралцагчийн үнэлгээ /цаашид “үнэлгээ” гэх/ нь суралцагчийн хөгжлийн ахиц, амжилтыг үнэлж, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, сургалтын зохион байгуулалтад тохируулга хийх, багшийн арга зүй, ур чадварыг сайжруулах, суралцагчийн хөгжлийг дэмжихэд чиглэнэ.

1.3.Энэхүү чиглэл нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/425 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/155 дугаар тушаалаар батлагдсан “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох бөгөөд тэдгээрт заасан нэр томъёог нэгэн адил ойлгоно.

Хоёр. Үнэлгээнд баримтлах зарчим

2.1.Үнэлгээ нь шалгуурт суурилсан, суралцагчийн хөгжлийн ялгаатай байдал, онцлог хэрэгцээг нь харгалзсан, агуулга, арга хэлбэр нь уян хатан, ялгаварлан гадуурхалтаас ангид байх;

2.2.Үнэлж дүгнэх үйл ажиллагаа нь бодитой, суралцагчийг урамшуулах, хөгжүүлэхэд чиглэсэн, тэдний сурах хүсэл эрмэлзэл, ахиц амжилтыг дэмжсэн, эцэг эх, асран хамгаалагчид нээлттэй, ил тод байх.

Гурав. Үнэлгээнд баримтлах чиглэл

3.1.Үнэлгээ нь оношлох, явцын, үр дүнгийн гэсэн төрөл хэлбэртэй байна.

3.2.Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний зорилтын хэрэгжилтийг илрүүлэх шалгуурыг багш боловсруулж, заах аргын нэгдлээр хэлэлцүүлж, сургалтын менежер батална.

3.3.Оношлох үнэлгээ нь суралцагчийн хөгжлийн түвшин, онцлог хэрэгцээг тогтоох, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний зорилтыг тодорхойлох үндэслэл болно.

3.4.Явцын үнэлгээг суралцагчийн суралцах үйлийг дэмжих, тэднийг урамшуулах, суралцах явцад тулгарч буй бэрхшээл, ахиц өөрчлөлтийг илрүүлж багшлах арга зүйдээ тохируулга хийх зорилгоор сургалтын явцад тогтмол хийнэ. Явцын үнэлгээг сургалтын баримт бичигт стандарт бус үнэлгээгээр тэмдэглэж болно.

3.5.Үр дүнгийн үнэлгээ нь ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт, суралцагчийн ахиц амжилтыг тооцох зорилгоор энэхүү чиглэлийн 1.3-т заасан журмын 3.8-д заасан хугацаанд хийнэ.

3.6. Үр дүнгийн үнэлгээг энэ чиглэлийн 3.2-т заасан шалгуурын дагуу боловсруулсан даалгаврын гүйцэтгэл болон явцын үнэлгээний тэмдэглэлийг харгалзан дараах хүснэгтийн дагуу хийнэ.

Суралцагчийн үр дүнгийн үнэлгээ	
Суралцагчийн овог, нэр:	
	Суралцагчийн үр дүнгийн үнэлгээ, хувь
<p>Оношлох үнэлгээний үр дүн /ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэхээс өмнөх үеийн нөхцөл байдал/:</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>	<p><input type="checkbox"/> хангалттай сайн: Суралцагч дэвшүүлсэн зорилгодоо хангалттай сайн хүрсэн 80-100 хувь</p> <p><input type="checkbox"/> хангалттай: Суралцагч дэвшүүлсэн зорилгын 60-79 хувьд хүрсэн</p> <p><input type="checkbox"/> ахиж байгаа: Суралцагч дэвшүүлсэн зорилгын 40-59 хувьд хүрсэн</p> <p><input type="checkbox"/> дэмжлэг хэрэгтэй: Суралцагч дэвшүүлсэн зорилгын 40 хүртэлх хувьд хүрсэн.</p>
<p>Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний зорилго:</p> <p>.....</p>	
Огноо:	<p>Багшийн тэмдэглэл: Суралцагчийн үр дүнгийн үнэлгээний тайлбарыг явцын үнэлгээний баримт нотолгоонд үндэслэн бичнэ.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>Үнэлгээ хийсэн багш:</p> <p style="text-align: center;">нэр, гарын үсэг</p>
Танилцсан:	<p>Эцэг эх, асран хамгаалагч:</p> <p style="text-align: center;">нэр, гарын үсэг</p>
	<p>Үнэлгээг эцэг эх, асран хамгаалагчид танилцуулж, хүүхдээ дэмжих чиглэлээр өгсөн зөвлөгөөг бичих</p> <p>.....</p> <p>.....</p>

3.7. Суралцагчийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн хэрэгжүүлж буй дэмжих үйлчилгээний сургалт /хэл засал, хөдөлгөөн засал, ахуй засал, орон зай, хөдөлгөөний баримжаа, дохионы хэл, брайл бичиг гэх мэт/-д хамрагдаж буй суралцагчийн ахиц өөрчлөлтийг энэ чиглэлийн 3.4 дэх заалтын дагуу үнэлнэ.

3.8. Суралцагчийн хөгжлийн онцлог, авьяас чадварт суурилан дүрслэх урлаг, хөгжим, техник технологи, зохион бүтээх, спортын чиглэлээр хичээллэсэн үр дүнг энэ чиглэлийн 1.3-д заасан журмын 3.11-д заасны дагуу үнэлж, сургалтын төлөвлөгөөний холбогдох судлагдахууны үнэлгээнд тооцож болно.

3.9. Үр дүнгийн үнэлгээг заах аргын нэгдлээр хэлэлцэж, тухайн суралцагч цаашид ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр үргэлжлүүлэн хичээллэх эсэхийг шийдвэрлэнэ.

Дөрөв. Үнэлгээг дүйцүүлэх, баталгаажуулах

4.1.Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж буй суралцагчийн үр дүнгийн үнэлгээний түвшнийг “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын 3.11-т заасан үнэлгээний түвшинтэй дараах байдлаар дүйцүүлнэ.

Энэ чиглэлийн 1.3-д заасан журмын 3.11-д заасан үнэлгээ		Энэхүү чиглэлийн 3.4-д заасан үр дүнгийн үнэлгээ, хувь
Түвшин	Хувь	
V	60-69	хангалттай сайн: Суралцагч дэвшүүлсэн зорилгын 80-100 хувьд хүрсэн
IV	50-59	хангалттай: Суралцагч дэвшүүлсэн зорилгын 60-79 хувьд хүрсэн
III	40-49	ахиж байгаа: Суралцагч дэвшүүлсэн зорилгын 40-59 хувьд хүрсэн
II	30-39	дэмжлэг хэрэгтэй: Суралцагч дэвшүүлсэн зорилгын 40 хүртэлх хувьд хүрсэн.
I	0-29	

4.2.Үр дүнгийн үнэлгээг багшийн журнал, суралцагчийн хувийн хэргийн холбогдох хэсэгт зааврын дагуу тэмдэглэн эцэг эх, асран хамгаалагчид хагас жил, жилийн эцэст танилцуулж, гарын үсэг зуруулна.

4.3.Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж буй суралцагчийг орон нутгийн болон үндэсний түвшинд зохион байгуулж буй тухайн судлагдахууны сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх чанарын үнэлгээнд хамруулахгүй байж болно.

4.4.Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэсэн суралцагчийн анги дэвших шалгалтын үнэлгээг аймаг, нийслэлийн боловсролын газар, улсын шалгалтын үнэлгээг боловсролын үнэлгээний байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу сургуулийн захирлын тушаалаар томилогдсон шалгалтын комисс шийдвэрлэнэ.

4.5.Суралцагчийн хандлага төлөвшилд гарсан ахиц өөрчлөлтийг хичээл заадаг болон анги удирдсан багшийн тэмдэглэл, баримт нотолгоонд үндэслэн дүгнэж, суралцагчийн хувийн хэрэгт тэмдэглэнэ.

Тав. Бусад

5.1.Суралцагчийн ахиц, амжилтыг тооцох, зөвлөн туслах зорилгоор сургууль, аймаг нийслэлийн боловсролын газраас хөндлөнгийн үнэлгээ хийж болно.

5.2. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэсэн суралцагчийн хүсэлтийг харгалзан анги дэвших болон улсын шалгалтад хамруулж болно.

5.3. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэсэн суралцагчийн ахиц өөрчлөлтийг хичээл заасан багшийн ажлыг үнэлэх, урамшуулахад харгалзан үзэж болно.

... оОо ...